



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

**ИРГЭДИЙН ИНФЛЯЦЫН
ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА**
2026 оны I улирал

2026 оны 4 дүгээр сар




I. ХУРААНГУЙ

Улсын инфляцыг 2025 оны III улирлаас эхлэн бодлогын шийдвэрт ашиглаж эхэлсэнтэй уялдуулж, өмнөх улирлын судалгаанаас эхлэн хамрах хүрээг улсын хэмжээнд болгон өргөжүүлсэн билээ. Энэ удаагийн судалгааг мөн улсын хэмжээнд 2026 оны 4 дүгээр сарын 3-17-ны өдрүүдэд зохион байгуулж, Монгол Улсад оршин суугаа нийт хүн амын байршил, хүйс, насны бүлэг, өрхийн орлогын бүтцийг төлөөлөх нийт 1,848 иргэд судалгаанд хамрагдлаа. Судалгааны голлох үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

- Судалгаанд 26-55 насны дээд боловсролтой, эмэгтэй иргэд түлхүү оролцлоо.
- Түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн хариултад үндэслэн хүлээгдэж буй инфляцын түвшнийг тооцоход ирэх 3 сард (2026 оны II улирлын эцэст) одоогийн түвшнээс бага зэрэг нэмэгдэхээр буюу өмнөх улирлын үр дүнгээс 0.5 нэгж хувиар өслөө. Түүнчлэн ирэх 12 сарын хувьд (2027 оны I улирлын эцэст) өмнөх улирлын утгаас ойролцоогоор 0.3 нэгж хувиар нэмэгдэж, инцляц одоогийн түвшнээс нэлээдгүй нэмэгдэх хүлээлттэй гарлаа. Ийнхүү инфляцын хүлээлт богино хугацаанд зорилтот түвшний дээд интервалын орчимд хадгалагдах бол цаашлаад жилийн дараа **9.0 орчим хувь** болж зорилтот түвшнээс давах төлөвтэй байна (Зураг 1).
- Улаанбаатар хотод инфляцыг харьцангуй өндөр буюу ирэх 3 сард **8.5%**, ирэх 12 сард **9.9%**-тай байна гэсэн хүлээлттэй байна.
- Өрхийн орлогын хүлээлт бага зэрэг өсөж, зардлын хүлээлт өмнөх улирлаас бага зэрэг буурсан хэдий ч өрхийн хуримтлалын хүлээлт бага зэрэг муудсан дүр зурагтай гарлаа.
- Иргэдийн дунд ажил эрхлэлт бага зэрэг буурах хүлээлт давамгайлж байна. Мөн эдийн засаг удаашрах, төгрөгийн ханш үргэлжлэн сулрах, зээлийн хүү нэмэгдэх хүлээлттэй гарлаа.

Зураг 1. Инфляцын хүлээлт




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

I. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ


Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн чанарын хариултад үндэслэн өнгөрсөн хугацааны үнийн мэдрэмжийн индексийг тооцоход өнгөрсөн 3 болон 12 сарын хугацааны хувьд өмнөх улирлын судалгааны үр дүнгээс бага зэрэг буурсан хэдий ч “инфляц өссөн” мужид хэвээр хадгалагдлаа (Зураг 2).

Мөн ирэх хугацааны инфляцын хүлээлтийн индексийг тооцоход ирэх улирлын болон ирэх 1 жилийн хүлээлтийн индексийн утгууд өмнөх улирлаас нэлээдгүй өсөж, “инфляц өснө” мужид хэвээр хадгалагдлаа. Тус индексийн хувьд 2025 оны туршид дараалан буураад байсан хэдий ч энэ удаагийн судалгаанд өмнөх улирлаас багагүй өссөн нь 2025 оны эхний улиралд гарсан өөрчлөлттэй ойролцоо байв (Зураг 3).

Зураг 2. Инфляцын мэдрэмжийн индекс¹



Зураг 3. Инфляцын хүлээлтийн индекс




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Түүнчлэн ирэх хугацааны инфляцын хүлээлтийн тоон хариултад үндэслэн дундаж утгыг тооцоход 2026 оны II улиралд **7.8%**, 2027 оны I улиралд **9.0%** гарсан бол медиан² утга харгалзан **7.9%**, **8.9%**-тай гарлаа (Зураг 4, Зураг 5). Эдгээр нь өмнөх улирлын үр дүнгээс 0.2-0.5 нэгж хувиар өссөн үзүүлэлт бөгөөд богино хугацаанд инфляцын хүлээлт зорилтот түвшинд хадгалагдах хүлээлт давамгайлж байгаа ч жилийн дараа зорилтот түвшнээс давах хүлээлттэй байна.


¹ Бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өнгөрсөн хугацаатай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн талаар мэдрэмжийг асууж, “маш ихээр өссөн”, “нэлээдгүй өссөн”, “аажмаар өссөн”, “хэвэндээ” болон “буурсан” гэсэн хариултуудыг [3;-1] утгаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон болно.

² Тоон асуулгын хариултаас [Nicholas J. Cox \(2009\)](#)-ийн боловсруулсан “Хагас тархалтын функц” болон “Симметрик шугаман интерполяци медиан” аргачлалыг ашиглан тоон хүлээлтийн тархалт болон медиан утгыг тооцсон болно.

Зураг 4. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан болон дундаж утга, ирэх 3 сар




Зураг 5. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан болон дундаж утга, ирэх 12 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх 3 сарын инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалтаас харахад өмнөх улиралд 9% орчимд илүү төвлөрөлтэй байсан бол энэ удаад тархалт харьцангуй жигд бүтэцтэй болж 7%-9% орчимд төвлөрчээ (Зураг 6). Харин ирэх 12 сарын инфляцын хүлээлтийн тархалтын хувьд өмнөх улиралд 9% орчимд буюу тодорхой голч утгатай байсан бол энэ удаад илүү өргөжсөн бүтэцтэй болж, 7%-11% орчимд төвлөрчээ (Зураг 7). Өөрөөр хэлбэл, тархалтын өргөжилт нь инфляцын хүлээлт илүү тогтворгүй болж, эрсдэлийн үнэлгээ илүү олон хувилбартай болж байгааг харуулж байна.

Зураг 6. Инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалт, ирэх 3 сар




Зураг 7. Инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалт, ирэх 12 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Инфляцын хүлээлтийн чанарын хариултад үндэслэсэн тархалтаас харахад 2026 оны I улиралд “өснө” гэсэн ангилалд давамгайлж, иргэдийн 64% нь “өнөөгийн түвшнээс илүү өснө” гэж хариулжээ. Харин “буурна” гэсэн хүлээлт бүрэн алга болж, “үнэ хэвээр байна” гэсэн хариулт 3%-д хүрсэн нь инфляцын бууралт ойрын хугацаанд огт хүлээгдээгүй байна. Өмнөх улирлын үр дүнтэй харьцуулахад “илүү өснө” гэсэн хүлээлт огцом нэмэгдлээ (Зураг 8).


Зураг 8. Инфляцын хүлээлтийн чанарын хариултын тархалт, ирэх 3 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Харин ирэх 12 сарын үнийн хүлээлтийн хувьд инфляц илүү өсөх хүлээлт өмнөх улирлаас 16 нэгж хувиар өссөнөөр судалгаанд оролцогчдын 73%-д нь инфляц илүү өсөх хүлээлт давамгайллаа (Зураг 9).


Зураг 9. Инфляцын хүлээлтийн чанарын хариултын тархалт, ирэх 12 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх 3 сарын инфляцын хүлээлт Улаанбаатар хотод 8.5%-д хүрч зорилтот түвшнээс бага зэрэг өндөр гарсан бол орон нутагт 7.3%-тай буюу зорилтот түвшний интервалд хадгалагдлаа. Харин ирэх 12 сарын хүлээлт Улаанбаатар хотод 9.9%, орон нутагт 8.3%-тай гарч, аль аль нь зорилтот түвшнээс давах төлөвтэй байна (Зураг 10, Зураг 11). Энэ нь богино хугацаанд инфляцын дарамт харьцангуй тогтвортой хадгалагдах ч урт хугацаанд нэмэгдэж болзошгүйг харуулж байна. Инфляцын хүлээлтийн дундаж утгын зөрүүг бүс нутгийн түвшинд харахад Улаанбаатар хотын иргэдийн хүлээлт 1.4 орчим нэгж хувиар илүү өндөр байна. Энэ нь байр сууцны зардал, хүнсний бүтээгдэхүүний эх үүсвэр зэрэг хэрэглээний ялгаатай бүтцээс шалтгаалж байна.

Зураг 10. Инфляцын хүлээлтийн дундаж утга, байршлаар (ирэх 3 сар)




Зураг 11. Инфляцын хүлээлтийн дундаж утга, байршлаар (ирэх 12 сар)




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх хугацааны инфляцын хүлээлтийг насны бүлгээр харьцуулахад бүх насны бүлэгт өмнөх улирлаас нэмэгдлээ. Тодруулбал, 2026 оны II улиралд 55-с дээш настай иргэдийн хувьд 0.9, 36-55 насны бүлэгт 0.6, 36-с доош насны бүлэгт 0.1 нэгж хувиар тус тус өсөж харгалзан **8.5%**, **8.0%** болон **7.2%** гарлаа (Зураг 12). Ирэх 12 сарын инфляцын хүлээлтийн хувьд өмнөх улирлаас мөн нэмэгдэж, ирэх 3 сарын хүлээлтийн утгаас насны бүлэг тус бүрт 1.2 орчим нэгж хувиар өндөр гарлаа (Зураг 13).

Зураг 12. Инфляцын хүлээлтийн дундаж утга, насны бүлгээр (ирэх 3 сар)




Зураг 13. Инфляцын хүлээлтийн дундаж утга, насны бүлгээр (ирэх 12 сар)




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Инфляцын хүлээлтийн утгыг орлогын ангиллаар харахад дундаж болон харьцангуй өндөр орлоготой иргэдийн хувьд өмнөх улирлаас тус бүр 0.6 нэгж хувиар өсөж, ирэх 3 сард **8.0%**, ирэх 12 сард **9.2%**-тай гарлаа. Харин харьцангуй бага орлоготой бүлгийн хувьд инфляц ирэх 3 сард **7.3%**, ирэх 12 сард **8.4%** байхаар хүлээгдэж байна (Зураг 14, Зураг 15).

Зураг 14. Инфляцын хүлээлтийн дундаж утга, орлогын ангиллаар (ирэх 3 сар)



Зураг 15. Инфляцын хүлээлтийн дундаж утга, орлогын ангиллаар (ирэх 12 сар)




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа


II. ӨРХИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ

Өрхийн орлогын болон зардлын хүлээлтүүд 2024 онд оргилдоо хүрч, түүнээс хойш буурах хандлагатай байна. 2026 оны эхний улиралд хүлээлтүүд бага зэрэг тогтворжсон ч бодит цалингийн индекс буурч, хэрэглээний өсөлт удааширч байна (Зураг 16, Зураг 17).

Зураг 16. Өрхийн орлогын хүлээлт, ирэх 3 сар



Зураг 17. Өрхийн зардлын хүлээлт, ирэх 3 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

Өрхүүдийн хадгаламжийн хүлээлт сүүлийн 8 улирал дараалан буурах чиглэлд гарлаа (Зураг 18).


Иргэдийн хугацаатай хадгаламж 2026 оны I улирлын эцэст 21.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар өсөөд байна. Харин банкуудаас авсан иргэдийн хэрэглээний зээлийн үлдэгдэл мөн үеийн байдлаар 13.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 орчим хувиар өссөн. Нөгөө талаас чанаргүй зээлийн эзлэх хувь өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар өсөж 5.1% буюу сүүлийн 7 улиралд тасралтгүй өссөнөөр 2021 оны түвшинд хүрлээ. Өөрөөр

хэлбэл, хадгаламжийн өсөлт эерэг хандлагатай байгаа хэдий ч хэрэглээний зээлийн чанар муудаж буй нь өрхүүдийн санхүүгийн эмзэг байдал нэмэгдэж байж болзошгүйг илтгэж байна.


Ирэх улиралд санхүүгийн байдлаа төлөвлөхөд хүндрэлтэй байна гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь үзэж байна. Тус үзүүлэлт өмнөх улирлаас бага зэрэг нэмэгдсэн дүр зурагтай байна (Зураг 19).

Иргэдийн банкнаас авсан хэрэглээний зээлийн үлдэгдэл, түүний жигнэсэн дундаж хүү болон хугацаагаар зээлийн сарын дундаж төлбөрийг тооцоход 2026 оны I улирлын байдлаар 703.8 мянган төгрөг болж байна. Энэ нь өрхийн сарын дундаж нэрлэсэн орлогын³ 23.4%-тай дүйцэж байна.

Зураг 18. Өрхийн хадгаламжийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 19. Санхүүгийн байдлын төлөвлөлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк, ҮСХ

III. МАКРО ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ХҮЛЭЭЛТ


Ажил эрхлэлтийн талаарх хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлын утгаас бага зэрэг буурч, ирэх улиралд ажил эрхлэлт буурах төлөвт гарлаа (Зураг 20). ҮСХ-ны мэдээгээр ажиллагчдын тооны өсөлт сүүлийн 4 улирал дараалан буурсан бол өмнөх оны мөн үес 2.2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Мөн эдийн засгийн өсөлтийн хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлаас 0.13 нэгжээр буурч - 0.36 утгатай буюу эдийн засаг агших хүлээлттэй гарлаа (Зураг 21).

³ ҮСХ, “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”, 2025 оны IV улирал

Зураг 20. Ажил эрхлэлтийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 21. Эдийн засгийн байдлын талаарх хүлээлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, УСХ


2026 оны I улиралд 1 ам.доллар дунджаар 3,564.5 төгрөгтэй тэнцэж, өмнөх оны мөн үеэс 3.2%-иар сулраад байна. Төгрөгийн ханш ирэх улиралд үргэлжлэн суларна гэж иргэдийн дийлэнх үзэж байна (Зураг 22).

Зээлийн хүүний хувьд ирэх улиралд хүү өсөх хүлээлт иргэдийн дунд давамгайлж, өмнөх улирлын утгаас бага зэрэг өслөө (Зураг 23). Иргэдэд банкнаас олгосон хэрэглээний зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар буурч 2026 оны I улирлын байдлаар 17.4%-тай байна.

Зураг 22. Гадаад валютын ханшийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 23. Зээлийн хүүний талаарх хүлээлт, ирэх 3 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк


IV. ХАВСРАЛТ

“Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-г 2026 оны 4 дүгээр сарын 3-17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, өмнөх улирлуудын судалгаанд оролцож байсан насанд хүрсэн иргэдээс утсаар ярилцлага хийх байдлаар (766), орон нутгийн иргэдээс ярилцлага хийх байдлаар (942) болон дурын утасны дугаарлалт үүсгэж⁴ масс мессеж илгээх байдлаар буюу санамсаргүй түүвэрлэлтээр (140) цуглуулсан бөгөөд нийт 1,848 иргэдээс судалгааны мэдээлэл цуглууллаа. Судалгаанд оролцсон эдгээр иргэд нь улсын хэмжээнд эх олонлогоо бүрэн төлөөлөх чадвартай байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын оршин суугаа хаягийг ҮСХ-оос зарласан 2025 онд Улаанбаатарт оршин суугаа хүн ам (насанд хүрсэн иргэд)-ын бүтэцтэй харьцуулахад харгалзан пропорциональ байна (Зураг 24). Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргийн иргэд Улаанбаатар хотын 44.7% бүрдүүлсэн бол орон нутгийн аймгууд тус бүр 5 орчим хувийг бүрдүүллээ (Зураг 25). Энэ удаагийн судалгаанд оролцогчдын 59% нь эмэгтэй, 41% нь эрэгтэй байна.

Зураг 24. Судалгаанд оролцогчдын оршин суугаа дүүрэг, эзлэх хувиар



Зураг 25. Судалгаанд оролцогчдын оршин суугаа аймаг, эзлэх хувиар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ


Мөн судалгаанд оролцогчдыг насны ангиллаар харвал 26-55 насны иргэд 74%-ийг бүрдүүлсэн бөгөөд энэхүү насны бүлэг нь Монгол Улсад оршин суугаа нийт хүн амын 69%-ийг бүрдүүлдэг буюу насны бүлэг тус бүр харгалзан нийцтэй байна. Боловсролын хувьд дээд болон бүрэн дунд боловсролтой иргэд тус судалгаанд түлхүү хамрагдлаа (Зураг 26, Зураг 27).

⁴ “Random Digit Dailing” аргачлалыг 2025 оны 2 улирлын түүвэр судалгаанаас эхлэн ашиглаж байгаа бөгөөд энэхүү аргачлалаар түүврийн тодорхой хэсгийг бүрдүүлснээр судалгаанд оролцогч иргэдийн мэдээллийг шинэчлэх, шинэ оролцогчдыг элсүүлж, мэдээллийн санг өргөжүүлэх, насны бүлгийн залуу төлөөллүүдийн хувьд судалгаанд оролцох магадлалыг нэмэгдүүлэх, түүвэр судалгааны мэдээлэл цуглуулах цаг хугацаа, зардал хэмнэх зэрэг давуу талтай байна. Одоогоор нийт түүврийн 10 хүртэл хувийг энэхүү аргачлалаар мэдээлэл цуглуулахыг зорьж байна.

Зураг 26. Судалгаанд оролцогчдын насны ангилал



Зураг 27. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

Ажил эрхлэлтийн хувьд энэ удаагийн судалгаанд хувийн болон төрийн байгууллагад ажилладаг иргэд голлон хамрагдлаа (Зураг 28). Судалгаанд оролцогч иргэдийн өрхийн орлогын бүлэг нь ҮСХ-оос зохион байгуулдаг “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-ны өрхүүдийг мөнгөн орлогоор бүлэглэсэн хамгийн сүүлийн буюу 2025 оны IV улирлын үр дүнтэй харгалзан нийцтэй байна (Зураг 29).

Зураг 28. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлт



Зураг 29. Судалгаанд оролцогчдын орлогын бүлэглэлт



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ